



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/203

Улаанбаатар хот

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээг зохицуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2024 оны "Томуу, томуу төст өвчний үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохицуулах тухай" А/435 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө батлах тухай" А/1247 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бага насны хүүхдийн амьсгалын замын өвчлөл, томуу, томуу төст өвчний тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн нийслэлийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг ажлын өдөр 21:00 цаг хүртэл, амралтын өдөр 11:00-18:00 цаг, нийтээр амрах баярын өдөр 10:00-15:00 цагийн хооронд уртасгасан цагаар ажиллуулахыг анхан шатны эрүүл мэндийн байгууллагын дарга нарт даалгасугай.

2. Уртасгасан цагаар ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтний илүү цагийн хөлсийг биеэр эсвэл батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг байгууллагын дарга нарт даалгасугай.

3. Эрсдэлт бүлгийн хүн ам болон нярай, бага насны суурь өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй, эмнэлэгт хэвтээд гарсан, нийслэлийн түргэн тусламжийн төв, нэгдсэн эмнэлгийн хүлээн авах тасаг, хүүхдийн кабинетаар үзүүлээд буцсан, гэрээр эмчлэгдэж буй хүүхдэд гэрийн идэвхитэй эргэлтийг эрчимжүүлж ажиллахыг өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга нарт, уртасгасан цагийн үзлэг болон дээрх үйл ажиллагаанд өдөр тутмын хяналт тавин, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг дүүргийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны "Томуу, томуу төст өвчний үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохицуулах тухай" А/175, 2024 оны "Томуу, томуу төст өвчний үеийн Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээг зохицуулах тухай" А/191 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс /Б.Батцоож/-д үүрэг болгосугай.

ДАРГА  П.ЭРХЭМБУЛГАН



1550001547